



МОНГОЛ УЛСЫН  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙДЫН  
ТУШААЛ

2016 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А-61

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Монгол мал үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2 дахь үе шатны (2016-2021 оны) үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтийг хавсралт ёсоор баталсугай.

2. Монгол мал үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2 дахь үе шатны үйл ажиллагааг бүх шатанд зохион байгуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Н.Ариунболд/-д даалгасугай.

3. Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилтийн хөрөнгө оруулалтын төсөвт тусган, санхүүжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Н.Ариунболд/, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга /А.Ануран/-д тус тус үүрэг болгосугай.

4. Хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан тайлагнаж байхыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /У.Саулел/-д үүрэг болгосугай.

САЙД

Р.БУРМАА

00000295

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны 04 дүгээр сарын  
29-ний өдрийн А/61 дүгээр тушаалын хавсралт

“МОНГОЛ МАЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2 ДАХЬ ҮЕ ШАТНЫ БУЮУ  
2016-2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөтөлбөрийн зорилт	Үйл ажиллагаа	Хугацаа (он)	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
<b>1. Мал аж ахуйн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох</b>				
1.1. Мал аж ахуйн салбар дахь хууль тогтоомжийг боловсронгуй болгох	1.1.1.Малын генетик нөөцийн тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэх	2016-2018	ХХААЯ	УИХ-ын БОХХАА-н байнгын хороо
	1.1.2.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэх	2016-2017	ХХААЯ	УИХ-ын БОХХАА-н байнгын хороо
	1.1.3. Бэлчээрийг хамгаалах тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэх	2016-2017	ХХААЯ	УИХ-ын БОХХАА-н байнгын хороо
	1.1.4.Мал аж ахуйн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж хэлэлцүүлэх	2017-2020	ХХААЯ	ХЗЯ
	1.1.5.Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийн заагийг тогтоох эрх зүйг бүрдүүлэх	2017-2018	ХХААЯ	БХБЯ
	1.1.6.Мал аж ахуйн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд төрөөс урамшуулал олгох системийг боловсронгуй болгох, эрх зүйн орчинг бүрдүүлэх	2017-2020	ХХААЯ	Сангийн яам
	1.1.7. Газрын тухай, Газрын төлбөрийн тухай хуульд хөдөө аж ахуйн эдэлбэр газрын ашиглалттай холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн санал боловсруулах, хэлэлцүүлэх	2017-2018	БХБЯ	ХХААЯ, ХЗЯ, СЯ
	1.1.9. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд Мал хамгаалах сангийн үйл ажиллагаатай холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн санал боловсруулах, хэлэлцүүлэх	2016-2017	СЯ	ХХААЯ, ХЗЯ
	1.1.8. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	2016-2017	СЯ	ХХААЯ, ХЗЯ
	1.1.9. Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	2017-2018	ХХААЯ	ХЗЯ, ОБЕГ
	1.1.10. Малын үржлийн ажил, үйлчилгээний стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулах	2016-2017	ХХААЯ	МЭҮГ
1.1.11. "Бэлчээр тэжээл", "Тэмээ" дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	2017-2021	ХХААЯ	Аймгийн Засаг дарга	
1.1. Мал аж ахуйн салбар дахь хууль тогтоомжийг боловсронгуй болгох	1.1.12.Мал аж ахуйн салбарт шинээр батлагдсан хуульд нийцүүлэн холбогдох журам, заавар, стандарт, стратегийн баримт бичгийн төслийг шинэчлэн боловсруулж батлуулах,	2016-2017	ХХААЯ	МЭҮГ, бүх шатны мэргэжлийн байгууллага, холбоо, нэгж
	1.1.13.Мал, амьтны эрүүл мэндийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх эрх зүй, эдийн засгийн нөхцлийг бүрдүүлэх	2016-2017	ХХААЯ	МЭҮГ

	1.1.14.Төрийн хяналт шалгалтын тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	2016-2017	ХХААЯ	МЭҮГ
	1.1.15.Мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эмийн үлдэгдлийг хянах үндэсний хөтөлбөр боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах.	2016-2017	ХХААЯ	МЭҮГ, УМЭАЦТЛ
	1.1.16.Малаас хүнд дамжин халдварладаг бруцеллёз өвчнийг мэргэжлээс шалтгаалах өвчний жагсаалтанд оруулахад шаардлагатай хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хийлгэх	2016-2017	ХХААЯ	МЭҮГ, Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төв
1.2. Мал эмнэлэг үржлийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэх, анхан шатны нэгжийг бэхжүүлэх.	1.2.1.Сумын мал эмнэлэг, үржлийн асуудал харицсан төрийн нэгжийн мэргэжилтэн, удирдлагын ур чадварыг сайжруулах, төсөв, санхүүгийн хуваарилалтанд зориулалтын ангилал бий болгож технологит үйл ажиллагааны хараат байдлыг арилгах	2016-2021	ХХААЯ	СЯ, бүх шатны Засаг дарга
	1.2.2. Мал үржүүлэг, технологийн болон мал эмнэлэгийн ажил, үйлчилгээ эрхэлдэг хувийн хэвшлийн нэгжийн стандарт, чиг үүрэг, хариуцлага, хяналтын тогтолцоог шинэчлэх	2016-2019	ХХААЯ	МЭҮГ, бүх шатны Засаг дарга, аймаг, нийслэлийн ХХААГ, мэргэжлийн холбоод
	1.2.3. Мал үржүүлэг, технологийн болон мал эмнэлэгийн ажил, үйлчилгээний нэгжийг аттестатчлах, ажил үйлчилгээний жишиг үнийн тарифыг шинэчлэн мөрдүүлэх	2017-2019	ХХААЯ	МЭҮГ, аймаг, нийслэлийн ХХААГ, мэргэжлийн холбоо
	1.2.4.Малд удам зүйн үнэлгээ хийх олон улсын системийг нэвтрүүлж, үржлийн малыг шилэн сонгох, баталгаажуулах, шинжлэх ухааны үндэслэлтэй үржил селекцийн ажлыг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих	2016-2021	МЭҮГ	ХХААЯ, МУСҮТ, бүх шатны Засаг дарга, аймаг, нийслэлийн ХХААГ, сумын тасаг
	1.2.5.Монгол Улсын малын генетик нөөцийн төлөв байдлын тайланг бүс нутгийн болон олон улсын холбогдох байгууллагад тогтмол хүргүүлэх, шуурхай мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг идэвхжүүлэх, туршлага судлах, сурталчлах	2016-2021	ХХААЯ	МЭҮГ, МУСҮТ, аймаг, нийслэлийн ХХААГ
1.2. Мал эмнэлэг үржлийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэх, анхан шатны нэгжийг бэхжүүлэх.	1.2.6. Мал эмнэлэгийн клиник үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх болон малын үржлийн ажил, үйлчилгээний нэгжийг бойжуулахад хөрөнгө оруулалт, хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх төслийг хэрэгжүүлэх	2016-2021	бүх шатны Засаг дарга	МЭҮГ, хувийн хэвшил, арилжааны банк
	1.2.7. Шилмэл хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулах, нийлүүлэх үржлийн аж ахуй, малчин өрхийн шаталсан тогтолцоог бодлого, эрх зүйн хүрээнд бий болгон баталгаажуулах, олон нийтэд зарлан таниулах	2016-2021	ХХААЯ	МЭҮГ, МУСҮТ, бүх шатны Засаг дарга, хувийн хэвшлийн нэгж, мэргэжлийн холбоо
	1.2.8.Мал эмнэлэгийн болон малын үржлийн нэг нэгжийн үйчилгээнд ногдох малын тоо толгойг бүсийн ялгавартайгаар тогтоох, үйлчилгээг төрөлжүүлэх, цар хүрээ, хүртээмж, үр дүнг сайжруулах	2017-2018	ХХААЯ	МЭҮГ, бүх шатны Засаг дарга, мэргэжлийн холбоод
	1.2.9.Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтанд авах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах	2017-2021	МЭҮГ	бүх шатны Засаг дарга, орон нутгийн мэргэжлийн байгууллага
	1.2.10. Орон нутагт ажиллаж буй мал аж ахуйн мэргэжилтэн, ажилтны эрх ашгийг хамгаалах, ажлын үр дүнг дүгнэх, урамшуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх	2016-2021	ХХААЯ	МЭҮГ, бүх шатны Засаг дарга, аймаг, нийслэлийн ХХААГ, мэргэжлийн холбоод

1.3. Мал аж ахуйн мэргэжилтэн, малчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, үйлдвэрлэлд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	1.3.1. Малчдыг мэдлэгжүүлэх болон залуу халааг бэлтгэхэд чиглэгдсэн зайн сургалтыг давтамжтай явуулах	2016-2021	ХХААЯ	ХААИС, бүх шатны Засаг дарга, ОУБ-ын төсөл
	1.3.2. Мал эмнэлгийн клиникийн болон сургалтын загвар аж ахуй шинээр байгуулж ур чадвартай малын эмч бэлтгэх, давтан сургах нөхцлийг бүрдүүлэх	2017-2020	ХААИС	МЭҮГ, ХААИС, ОУБ-ын төсөл, хувийн хэвшлийн нэгж
	1.3.3. Мал зүйн мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах сургалтын төлөвлөгөөг шинэчлэх, мэргэжилтэнг орон нутаг, хувийн хэвшлийн нэгжийн захиалгаар бэлтгэх тогтолцоог дэмжин хөгжүүлэх	2017-2021	ХААИС	БСШУЯ, ХХААЯ, МЭҮГ, бүх шатны Засаг дарга, хувийн хэвшлийн нэгж
	1.3.5. Мал аж ахуйн мэргэжилтнүүдийн төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх тэнхимийн болон зайн сургалтыг хөгжүүлэх, мэргэжлийн ур чадварыг тодорхойлж мэргэшлийн зэрэг олгох системийг боловсронгуй болгох	2017-2019	ХХААЯ	МЭҮГ, мэргэжлийн холбоод, ОУБ-ын төслийн нэгж
	1.3.6. Малчид, мал бүхий иргэдэд малын бүртгэл мэдээллийн систем, мал сүргийн бүтэц, чанар, эдийн засгийн эргэлт, эрчимжүүлэх арга, туршлагын талаарх сургалтыг багийн түвшинд хийх, сурталчлах, тэдгээрийн ач холбогдлыг таниулах	2016-2021	ХХААЯ	ХААИС, МААЭШХ, МЭҮГ, мэргэжлийн холбоод, ОУБ-ын төслийн нэгж
	1.3.7. Малчин, малын эмч, мал зүйч, хээлтүүлгийн техникч нарыг хөдөлмөрийг хүнд, хортой нөхцөлд хамааруулах, гэрээт ажилчид, туслах малчдын нийгмийн хамгааллын баталгааг ажил олгогчоор хангуулах	2016-2019	ХХААЯ	НХЯ, ХЯ, МЭҮГ, бүх шатны Засаг дарга, мэргэжлийн холбоод
	1.3.8. Орон нутгийн санаачлагад үндэслэн малын нөхөн үржүүлэгийн техникч, мэргэжилтний хүрэлцээг нэмэгдүүлэх	2016-2021	МУСҮТ	бүх шатны Засаг дарга, хувийн хэвшлийн нэгж
<b>2. Малын үржлийн ажил, үйлчилгээг нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгож, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулан өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх</b>				
2.1. Монгол малын ашигтай, онцлог шинж чанарыг баталгаажсан цөм сүргээр бататган сайжруулж, удам зүй, сонгон үржүүлгийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж биологийн боломжийг бүрэн ашиглах	2.1.1. Монгол улсад үржүүлж буй баталгаажсан үүлдэр, омгийн малын ашиг шимийн түвшинг тогтоож, шинэчилсэн стандарт боловсруулж батлуулах	2017-2019	ХХААЯ	МЭҮГ, МУСҮТ, ҮСХ, МААЭШХ, мэргэжлийн холбоо
	2.1.2. Мал, амьтны үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, бүс нутгийн онцлогт тохирсон үржлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, технологийн хяналт тавих, шинэ үүлдэр, омгийн малыг бий болгох	2016-2021	МЭҮГ	МУСҮТ, бүх шатны Засаг дарга, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн нэгж
	2.1.3. Монгол үхрийн амьдын жинг нэмэгдүүлэх, өөх-махны чиглэлийн хонины өөхийг багасгах, ямааны ноолуурын голчыг нарийсгахад чиглэгдсэн "Зорилтот үржил селекци" хөдөлгөөнийг өрнүүлж, илүү үр ашигтай шилмэл сүргийг үржүүлэх	2016-2021	МЭҮГ	ХХААЯ, МААЭШХ, МУСҮТ, аймгийн ХХААГ, мэргэжлийн нэгж, холбоо
	2.1.4. Улсын хэмжээнд шилмэл, гойд ашиг шимт малыг баталгаажуулах, олон нийтэд зарлах, сурталчлах, "Үржлийн шилмэл малын улсын бүртгэлийн ном"-ыг хөтлөдөг болох	2016-2021	МЭҮГ	ХХААЯ, МУСҮТ, бүх шатны Засаг дарга, мэргэжлийн холбоо
	2.1.5. Сүү, махны чиглэлийн үхэр, нарийн, нарийвтар ноост болон каракул арьсны хонь, сүүний чиглэлийн ямаа зэрэг төрөлжсөн үүлдрийн малыг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үржүүлэх	2016-2021	мал бүхий иргэн, хуулийн этгээд	МЭҮГ, МААЭШХ, мэргэжлийн холбоод

	2.1.6. Сүмбэр үүлдрийн хонь, Сэлэнгэ үүлдрийн үхэр, Орхон, Ерөө үүлдрийн нарийн, нарийвтар ноост хонины цусыг сэлбэх зорилгоор гадаадаас хээлтүүлэгч авах, үр дүнтэй ашиглах, үр дүнг харуулах	2016-2021	МЭҮГ	ХХААЯ, МУСҮТ, МААЭШХ, бүх шатны Засаг дарга, хувийн хэвшлийн нэгж
	2.1.7. Дорнодын мухар улаан, нугагшсан шар тарлан, алатау, хар тарлан үүлдрийн үхрийн удмын санг хамгаалах, цус сайжруулах ажлыг үе шаттай явуулах, үр дүнг бүртгэх	2017-2021	МЭҮГ	МУСҮТ, МААЭШХ, аймаг, нийслэлийн ХХААГ, тасаг, нэгж, мал бүхий иргэн, хуулийн этгээд
	2.1.8. Малын генетик нөөцийг ашиглах, хамгаалах чиглэлээр зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн болон үүлдрийн зөвлөлийг байгуулах	2017	ХХААЯ	МЭҮГ, мэргэжлийн холбоод
	2.1.9. Малын удам зүй, ашиг шимийн бүртгэлд суурилан мал үржүүлгийн бүсийг нарийвчлан тогтоох, мал эрлийзжүүлэгийн төлөв байдлыг сум, дүүргээр үнэлэн гаргах, мэдээлэх ажлыг зохион байгуулах	2017-2021	МЭҮГ	ХХААЯ, МУСҮТ, бүх шатны Засаг дарга, аймаг, нийслэлийн ХХААГ, тасаг, нэгж, мэргэжлийн холбоо
2.2. Малын удмын санг хамгаалж, биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэн малын бүтээмжийг нэмэгдүүлэх	2.2.1. Малын удмын сангийн үндэсний цогцолборын эхний ээлжийг ашиглалтанд оруулж малын генийн санг хамгаалах, баяжуулах, олон улсын стандартын шаардлага хангасан үр, хөврөл үрийг үйлдвэрлэх, шилжүүлэн суулгах	2016-2017	ХХААЯ	СЯ, МУСҮТ
	2.2.2. Үржлийн мал амьтан, тэдгээрийн генетикийн материалыг улсын хилээр нэвтрүүлэх ажлыг нэгдсэн бүртгэл, хяналттай болгох	2017-2021	ХХААЯ	МХЕГ, ГЕГ, МЭҮГ, МУСҮТ
	2.2.3. Молекул генетикийн шинжилгээний лабораторийг сайжруулах, боловсон хүчинг бэлтгэх	2017-2021	МУСҮТ	ХААИС, МЭҮГ, МААЭШХ
	2.2.4. Малын нөхөн үржихүйн биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх, гүн хөлдөөсөн үр, хөврөл үр ашиглах, үйлдвэрлэх чадавхи, бүтээмжийг нэмэгдүүлэх, боловсон хүчинг мэргэшүүлэх	2016-2021	ХХААЯ	МЭҮГ, МААЭШХ, МЗҮХ
	2.2.5. Тоо нь цөөрч байгаа зарим үүлдэр, омгийн малын байршлыг тогтоох, тэдгээрийн болон шилмэл малын генийг хадгалах, хамгаалах, тоо толгойг нэмэгдүүлэх	2017-2019	МУСҮТ	ХХААЯ, МЭҮГ, МААЭШХ, бүх шатны Засаг дарга, хувийн хэвшлийн нэгж
	2.2.6. Бүсийн төвүүдэд мал үржүүлэг, биотехнологийн төвийг болон зохиомол хээлтүүлгийн явуулын үйлчилгээ, пунктыг байгуулах, үр, азот, багаж хэрэгслээр хангах, техникч нарыг бэлтгэх	2016-2021	МУСҮТ	МЭҮГ, бүх шатны Засаг дарга, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн нэгж
2.3. Малын бүртгэл, мэдээллийн сан, сүлжээг бий болгох	2.3.1. Мал сүргийг хувийн дугаартай болгоход оролцогч талуудын идэвхи, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	2016-2021	ХХААЯ	МЭҮГ, ХЗЯ, бүх шатны Засаг дарга, ҮСХ
	2.3.2. Малын бүртгэл мэдээллийн санг тогтмол баяжуулах, аймаг, сум бүрээр улирал тутамд ажлыг дүгнэх, нийтэд зарлах системд шилжих	2016-2021	ХХААЯ	МЭҮГ, ХЗЯ, бүх шатны Засаг дарга, ҮСХ
	2.3.3. Малын бүртгэл мэдээллийн системийн техник хэрэгсэл, сүлжээг сайжруулах	2018-2021	МЭҮГ	ХХААЯ, аймаг, нийслэлийн ХХААГ, тасаг, нэгж
	2.3.4. Малын бүртгэл, мэдээллийн сан, сүлжээний асуудал хариуцсан орон нутгийн мэргэжилтнүүдийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх, бусад улс орны туршлагыг судлах, хамтарсан төсөл хэрэгжүүлэх	2016-2021	МЭҮГ	ХХААЯ, бүх шатны Засаг дарга, ОУБ, аймаг, нийслэлийн ХХААГ, сумын тасаг, нэгж
	2.3.5. Мал эмнэлгийн мэдээ, тайланг шуурхай болгох, цахим хэлбэрт шилжүүлэх, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах	2016-2020	МЭҮГ	Аймаг, нийслэлийн ХХААГ, сумын тасаг, нэгж

	2.3.6.Малын эрүүл мэнд, шилжилт хөдөлгөөн, алдсан, олдсон малыг мэдээлэх, мэргэжлийн зөвлөгөө өгөх төлбөргүй утасны үйлчилгээг сайжруулах	2016-2020	ХХААЯ	МЭҮГ
<b>3.Мал эмнэлгийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, малын эрүүл мэндийг баталгаажуулах замаар нийгмийн эрүүл мэндийг хамгаалах</b>				
3.1.Олон улсын худалдааны хориг бүхий малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сээрэмжүүлэх, тэмцэх арга хэмжээний бэлэн байдлыг өндөржүүлж, зооноз халдварт зарим өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх	3.1.1. Малын өвчний оношилгоо, шинжилгээнд олон улсын стандарт, цахим технологи нэвтрүүлэх, сүлжээгээр ажиллах эрх зүйн орчин, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, үндэсний лавлагаа лабораторийг төрөлжүүлэн хөгжүүлэх	2016-2018	ХХААЯ	МЭҮГ, УМЭАЦТЛ
	3.1.2. Малын халдварт өвчний тандалт, хяналтыг мал, амьтны эрүүл мэндийн олон улсын байгууллагын зөвлөмж арга зүйн дагуу гүйцэтгэх	2016-2021	МЭҮГ	ХХААЯ, бүх шатны мал эмнэлгийн байгууллагууд
	3.1.3.Адууны ям, халдварт цус багасах, өвчин, үхрийн лейкоз өвчингүй, тайван баг, сум, аймгийг нийтэд зарлан мэдээлэх, төрөөс олгох урамшуулал, санхүүгийн олон хувилбарт дэмжлэгийг “Эрүүл сүрэгтэн” аж ахуй, баг, сумын малчдад олгодог болох	2016-2021	МЭҮГ	ХХААЯ, бүх шатны мал эмнэлгийн байгууллагууд
	3.1.4.Малчин, үйлдвэрлэгч, хэрэглэгчдэд мал, амьтны эрүүл мэнд, нийтийн эрүүл мэндийн талаар мэдлэг олгон, малын өвчнөөс сэргийлэх, халдварт өвчнийг эрт илрүүлэх зохистой дадалуудыг нэвтрүүлэх	2016-2021	МЭҮГ	Сум дүүргийн МЭҮТ, мал эмнэлгийн үйлчилгээний нэгж
	3.1.5.Аймгийн мал эмнэлгийн албаны яаралтай дуудлагын болон халдваргүйтгэлийн автомашин, тоног, төхөөрөмжийг шинэчлэн бэлэн байдлын чадавхийг бэхжүүлэх	2017-2020	ХХААЯ	МЭҮГ
	3.1.6.Үхрийн цээж, үхрийн тархины эд сархиагах өвчингүй, тайван улс, шүлхий өвчингүй, тайван бүс бүхий улсын статусыг дотооддоо хүлээн зөвшөөрч зарлах, улмаар Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаар баталгаажуулах	2016-2021	МЭҮГ	ХХААЯ, бүх шатны мал эмнэлгийн байгууллагууд
	3.1.7.Шүлхий, бог малын цэцэг өвчинтэй тэмцэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлж, өвчний голомтыг бүрэн хяналтад авах	2016-2020	МЭҮГ	Бүх шатны мал эмнэлгийн байгууллагууд
	3.2.1.Мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн нэвтрүүлэх боомтууд болон өвчингүй, тайван бүс нутаг руу нэвтрэх хэсэгт халдваргүйжүүлэлтийн иж бүрэн камер, тоног төхөөрөмж, хорио цээрийн байгууламж байгуулж, хил даван халдварлах өвчний эрсдэлийг бууруулах	2017-2019	ХХААЯ	МЭҮГ, аймгийн ХХААГ
	3.1.8.Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд шинжлэх ухааны үндэстэй хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж малын эмчийн хариуцлагыг сайжруулах механизм бүрдүүлэх	2016-2021	МЭҮГ	Бүх шатны мал эмнэлгийн байгууллагууд
3.2.Мал эмнэлгийн албаны тогтолцоог олон улсын жишигт нийцүүлж, мал эмнэлгийн ажил, үйлчилгээг эдийн засаг, нийгмийн шаардлага, эрэлт хэрэгцээг бүрэн хангах түвшинд хүргэн сайжруулах	3.2.1.Хөрш орнууд болон худалдааны харилцаатай орнуудын мал эмнэлгийн байгууллагуудтай бүх талын хамтын ажиллагааг өргөтгөх	2016-2021	МЭҮГ	Бүх шатны мал эмнэлгийн байгууллагууд
	3.2.2.Мал эмнэлгийн албаны бүтэц, зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн зохион байгуулах	2016-2017	ХХААЯ	МЭҮГ
	3.2.3.Мал, амьтны тэжээлийн аюулгүй байдлын хяналтын тогтолцоог нэвтрүүлнэ	2016-2017	ХХААЯ, МЭҮГ	УМЭАЦТЛ
	3.2.4.Баруун, зүүн, төвийн бүсэд орчин үеийн шаардлагад нийцсэн тоноглол бүхий хорио цээрийн хяналтын цэг байгуулж, ажиллуулан мал, малын гаралтай бүтээгдэхүүний дотоодын тээвэр, шилжилт хөдөлгөөний хяналтын тогтолцоог олон улсад хүлээн зөвшөөрөх хэмжээнд хүргэх	2016-2020	ХХААЯ	МЭҮГ

3.3. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг олон улсын стандартын түвшинд хүргэх	3.3.1.Малын эм, мал эмнэлгийн хэрэгслийг ханган нийлүүлэх тогтолцоо, сүлжээг бий болгох, малын эмийн сангийн үйл ажиллагааг хууль, журмаар зохицуулах, улсын бүртгэлийг цахим хэлбэрт шилжүүлж, нэгдсэн сан бий болгох	2017-2021	ХХААЯ	МЭҮГ
	3.3.2.Биокомбинат ТӨААТҮГ-ын техник, технологийг шинэчлэх ажлын хэрэгжүүлж дуусгах	2016-2018	ХХААЯ	МЭҮГ, Биокомбинат ТӨААТҮГ
	3.3.3.Мал эмнэлгийн зориулалтаар хэрэглэгдэж буй эм, биобэлдмэл эмийн түүхий эдэд сорилт, туршилт, шинжилгээг орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	2017-2019	ХХААЯ	МЭҮГ, МЭЭСБУЛ
<b>4.Уур амьсгал, байгаль, экологийн өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадавхитай мал аж ахуйг хөгжүүлэх</b>				
4.1 Бэлчээрийн менежментийг сайжруулах	4.1.1.Байгаль, экологийн онцлогтой уялдуулан бэлчээрийн газарт бүсчлэл тогтоож, бүс тус бүрийн төлөв байдлыг үнэлэх, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, хэрэгжүүлэх	2016-2021	ХХААЯ	БХБЯ, бүх шатны Засаг дарга, ОУБ-ын төслийн нэгж, хувийн хэвшлийн нэгж
	4.1.2.Бэлчээрийн даац хэтрэлт өндөртэй 5-аас доошгүй аймагт бэлчээр ашиглалтын түр журмыг хэрэгжүүлж, малын тоо, төрөл, сүргийн бүтцийг зохицуулах замаар бэлчээрийг сайжруулах туршилтыг хийх, загвар сумдыг бий болгох	2017-2021	бүх шатны Засаг дарга,	ОУБ-ын төслийн нэгж, хувийн хэвшлийн нэгж
	4.1.3.Бэлчээрийн хортон мэрэгч, царцаатай байгальд халгүй аргаар тэмцэх, үлийн цагаан оготно устгах төхөөрөмжийг туршин нэвтрүүлж, бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх	2016-2021	ХХААЯ	бүх шатны Засаг дарга, аймгийн ХХААГ, тасаг, малчид
	4.1.4.Тариалангийн бүс нутагт болон 500-аас дээш малтай шилжих малчдын шилжилт хөдөлгөөнд нутагших Засаг захиргааны нэгжээс урьдчилсан зөвшөөрөл авах тогтолцоонд шилжүүлэх	2017-2021	ХХААЯ	ХЗЯ, бүх шатны Засаг дарга, малчид, хувийн хэвшлийн нэгж
4.1 Бэлчээрийн менежментийг сайжруулах	4.1.5.Малын тооноос хамааралтайгаар бэлчээрийн татварыг бий болгох, татварыг орон нутгийн санд төвлөрүүлэх, түүнийг бэлчээрийн нөхөн сэргээхэд ашиглах эрх зүй, бүтэц, зохион байгуулалтын нөхцлийг бүрдүүлэх	2017-2021	бүх шатны Засаг дарга	СЯ, ХХААЯ, ОУБ-ын төслийн нэгж, малчид, хувийн хэвшлийн нэгж
	4.1.6.Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутагт оторлох гэрээгээр ирээд буцахгүй байгаа зөрчлийг арилгуулах	2017-2021	АДОБНЗ	Бүх шатны Засаг дарга, малчид
	4.1.7.Бэлчээрийн нөхөн сэргээлтэнд үр бүтээмж өндөртэй таримал ургамлын үр сортыг бий болгох, өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	2017-2021	ХХААЯ	СЯ, ОУБ-ын төслийн нэгж, бүх шатны Засаг дарга, мал бүхий иргэн, хуулийн этгээд
	4.1.8.Бэлчээрийн даац хүндрэлтэй, бэлчээрийн ургамлын бүрэлдэхүүн багатай аймаг, суманд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх төслийг хэрэгжүүлэх	2017-2021	ХХААЯ	СЯ, ОУБ-ын төслийн нэгж, бүх шатны Засаг дарга, мал бүхий иргэн, хуулийн этгээд
4.2. Хадлан, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	4.2.1.Эрчимжсэн аж ахуй эрхлэгчид болон малчид малын тэжээл бэлтгэх, тэжээлийн ургамал тариалах, шинэ техник, тоног төхөөрөмж худалдан авахад орон нутгийн сангаас хөнгөлттэй зээлээр дэмждэг болох	2016-2021	бүх шатны Засаг дарга,	СЯ, Арилжааны банк, ОУБ-ын төслийн нэгж, хувийн хэвшлийн нэгж
	4.2.2.Тэжээлийн эрдэнэ шиш, наранцэцэг, царгас зэрэг нэг наст ургамал, олон настын таримлын сорт, сорилыг зүүн бүст эхлүүлэх, нутагшсан сорттой болох	2016-2021	ХХААЯ	ОУБ-ын төслийн нэгж
	4.2.3.Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд малын тэжээл тариалах зориулалтаар тариалангийн эдэлбэр газар гэрээгээр эзэмшихэд бодлогын дэмжлэг үзүүлэх	2016-2021	бүх шатны Засаг дарга	аймаг, нийслэлийн ХХААГ, тасаг, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид

	4.2.4.Сумын агропарк, техникийн үйлчилгээ эрхлэгчдийг түшиглэн малын тэжээл тариалах, хураах тоног төхөөрөмжөөр хангах	2016-2021	бүх шатны Засаг дарга	аймаг, нийслэлийн ХХААГ, тасаг, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид
	4.2.5.Олон найрлагат шахмал тэжээлийг бэлтгэх, үйлдвэрлэхэд өртөг хямд, орон нутгийн түүхий эдийг ашиглах	2016-2021	ХХААЯ	аймаг, нийслэлийн ХХААГ, тасаг, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид
4.3.Бэлчээрийн менежментийг сайжруулах	4.3.1.Бороо, цасны ус тогтоох, хөв, цөөрөм, усан сан байгуулах, энгийн болон гүний худаг байгуулах зэргээр бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх ажлыг орон нутгийн төсвөөр үе шаттай зохион байгуулах	2016-2021	бүх шатны Засаг дарга	ХХААЯ, аймаг, нийслэлийн ХХААГ, ОУБ-ын төслийн нэгж
	4.3.2.Одоо ашиглаж буй худгийн эзэмшилтийн бүртгэлийг шинэчлэх, ашиглалтыг сайжруулах	2017-2021	бүх шатны Засаг дарга	ХХААЯ, аймаг, нийслэлийн ХХААГ
	4.3.3.Уст цэгийн хайгуул хийх, цооног гаргахад мэргэжлийн байгууллагуудтай хамтран жишиг үнийн тарифыг гаргах, баталгаажуулах	2017-2019	ХХААЯ	Бүх шатны Засаг дарга, ОУБ-ын төслийн нэгж
4.4. Мал аж ахуйн эрсдэлийг бууруулах чадавхи бий болгох	4.4.1.Малын тоонд бус чанарт анхаарч уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, ашиг шимийн бүтээмж өндөртэй, түүхий эд, бүтээгдэхүүн нь чанартай малтай болох	2016-2021	БСШУЯ	ХХААЯ, бүх шатны Засаг дарга, ОУБ-ын төслийн нэгж
	4.4.2.Нийслэл, томоохон суурин газрын орчимд сүү, махны эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх дэд хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх	2016-2021	нийслэлийн Засаг дарга	ХХААЯ, хувийн хэвшлийн нэгж
	4.4.3.Малын даатгалын системийг боловсронгуй болгох, даатгалын компанийн хариуцлагыг нэмэгдүүлэх, индексжүүлсэн даатгалд хамрагдах малчин өрхийн тоог 20 хувьд хүргэх	2016-2021	Даатгалын компани	СЯ, ХХААЯ, СЗХ, бүх шатны Засаг дарга, ОУБ-ын төслийн нэгж, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж
	4.4.4. Цаг агаар хүндэрсэн үед ашиглах өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэлтийн тогтолцоог өөрчлөх, нөөцийн цэгийн тоог нэмэгдүүлэх	2017-2021	ОБЕГ	ХХААЯ, бүх шатны Засаг дарга, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж
<b>5. Мал, малын гаралтай түүхий эдийн бэлтгэлийн системийг боловсронгуй болгох</b>				
5.1. Мал, малын гаралтай түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох	5.1.1.Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын үнэлгээ, ариун цэврийн магадлан шинжилгээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, технологийг нэвтрүүлэх	2017-2021	МЭҮГ	ХХААЯ, МХЕГ, СХЗГ, МЭАЦТЛ, мэргэжлийн байгууллагууд
	5.1.2.Түүхий эдийн борлуулалтын зах зээл дэх ченжийн тогтолцоог өөрчлөх, түүхий эдийн үнийг тогтворжуулах	2016-2017	ХХААЯ	СХЗГ, МХЕГ, ХАА-н бирж, бүх шатны Засаг дарга
	5.1.3.Малын шилжилт хөдөлгөөнийг журамлах, хяналтыг сайжруулах	2016-2017	МЭҮГ	ХХААЯ, МХЕГ, бүх шатны Засаг дарга, аймаг, нийслэлийн ХХААГ, тасаг
	5.1.4.Түүхий эдийн бэлтгэлд ангилал, зэрэглэлийн дагуу ялгавартай үнийг тогтоож, чанарыг үнэлэх систем рүү шилжүүлэх	2017-2021	ХХААЯ	ХААБ, мэргэжлийн холбоод, аймаг, нийслэлийн ХХААГ, тасаг
	5.1.5.Зах зээлийг тэлэх буюу гадаад зах зээлд борлуулах, хил дамнасан хамтын ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох	2016-2021	ХХААЯ	АҮЯ, МХЕГ, МЭҮГ, бүх шатны Засаг дарга, хувийн хэвшлийн нэгж



	5.1.6.Арьс шир, ноосны агуулахыг суманд байгуулахад малчдын хоршоодод дэмжлэг үзүүлэх, мах, сүү, ноос, арьс ширэнд үзлэг шинжилгээ хийх багаж, техникээр хангах, мэргэжлийн боловсон хүчинг орон нутгаас сургах	2017-2021	АҮЯ	ХХААЯ, ХААБ, бүх шатны Засаг дарга, үндэсний үйлдвэрүүд, малчдын хоршоо
	5.1.7.Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, малчдын хоршоог биржийн арилжаанд оролцоход мэргэжил арга зүй, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх	2017-2021	ХХААЯ	ХААБ, бүх шатны Засаг дарга, ОУБ-ын төслийн нэгж, малчдын хоршоод
5.2. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эдийн засгийн урамшуулал бий болгох	5.2.1.Боловсруулах үйлдвэрт улирлын онцлогоос хамааран нийлүүлсэн мах, сүүнд урамшуулал олгох журмыг боловсруулж, хэрэгжүүлэх	2018-2021	ХХААЯ	СЯ, Монгол банк, МХС, бүх шатны Засаг дарга, мэргэжлийн нэгж, малчид
	5.2.2.Цөм сүргийн малыг үржүүлж, стандартын шаардлага хангасан өсвөр хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулан зах зээлд борлуулсан үржлийн нэгж, аж ахуйг урамшуулах нөхцлийг бүрдүүлэх	2019-2021	ХХААЯ	СЯ, МЭҮГ, бүх шатны Засаг дарга, ОУБ-ын төслийн нэгж, мэргэжлийн нэгж, малчид
5.3. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн маркетингийг сайжруулах	5.3.1.Монгол Улсын нүүдлийн мал аж ахуйн өв соёлыг хадгалж морь, тэмээг уналга, эдэлгээнд ашиглах, тоног хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр тусгайлсан арга хэмжээг малчдын дунд тогтмол зохион байгуулах	2017-2021	бүх шатны Засаг дарга	ХХААЯ, МЭҮГ, аймаг, нийслэлийн ХХААГ, тасаг, мал бүхий иргэд, малчид
	5.3.2.Хилийн боомт, мал төхөөрөх үйлдвэр, бүс нутгийн малын тооны нөөцөд суурилан махны экспортын төлөвлөгөөг аймаг, сумдаар тодорхойлох, мал, махны экспортыг нэг цонхны бодлого, хяналтаар гаргах	2016-2021	ХХААЯ	МХЕГ, ГЕГ, бүх шатны Засаг дарга, мэргэжлийн холбоод, иргэн, хуулийн этгээд
	5.3.3.Гадаад болон дотоод зах зээлд борлуулах махны стандартыг тусгайлан тогтоох, хонь, ямааны махыг экспортод түлхүү гаргахад малчдад дэмжлэг үзүүлэх	2016-2021	ХХААЯ	бүх шатны Засаг дарга, малчид, аж ахуйн нэгж
	5.3.4.Орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан зоорь, хөргөлтийн агуулах байгуулах аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж хаврын улиралд орон нутгаас мах борлуулах боломжийг бүрдүүлэх	2017-2021	ХХААЯ	бүх шатны Засаг дарга, малчид, аж ахуйн нэгж
	5.3.5.Монгол уламжлалаар бэлтгэж боловсруулсан сүүн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах сүлжээг хөгжүүлэх	2017-2021	ХХААЯ	бүх шатны Засаг дарга, малчид, аж ахуйн нэгж
	5.3.6.Өсвөр малыг богино хугацаанд бордож зах зээлд борлуулах технологийг өргөнөөр нэвтрүүлж зэх зээлд жилийн 4 улирлын туршид нойтон мах нийлүүлэх малыг эдийн засгийн эргэлтэнд оруулах	2017 - 2021	ХХААЯ	бүх шатны Засаг дарга, ЭШХ, их, дээд сургууль, мэргэжлийн холбоод
	5.3.7. Газар зүйн заалттай бүтээгдэхүүнийг олон улсын холбогдох байгууллагад бүртгүүлэх	2018-2019	ХХААЯ	Оюуны өмчийн газар, мэргэжлийн холбоод
	5.3.8. Түүхий эдийн нөөцийн хэмжээтэй уялдуулан малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрийн байршлыг шинэчлэн тогтоох, одоогийн үйлдвэрийн хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлэх	2017-2018	ХХААЯ	АҮЯ, МХЕГ, МЭҮГ, бүх шатны Засаг дарга, хувийн хэвшлийн нэгж
	5.3.9.МАН-гаас гарч байгаа мах, ноос, түүхий эдийг зах зээлийн эргэлтэд оруулах, ченжийн системийг халах, гадаад зах зээлд борлуулахад үнийг бууруулахгүйгээр зуучлах, арьс шир, ноосыг үндэсний үйлдвэрт тушаасан малчдын урамшууллыг үргэжлүүлэн олгох	2017-2021	ХХААЯ	АҮЯ, МХЕГ, МЭҮГ, бүх шатны Засаг дарга, хувийн хэвшлийн нэгж

Товчилсон үгийн тайлал:

УИХ-ын БОХХААБХ- Улмын Их Хурлын байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын Хороо

ХХААЯ -Хүнс, хөдөө аж ахуйн яам

СЯ-Сангийн яам

ГХЯ-Гадаад харилцааны яам

БОНХАЖЯ-Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам

АҮЯ-Аж үйлдвэрийн яам

ХЗЯ- Хууль зүйн яам

ХЯ-Хөдөлмөрийн яам

БХБЯ-Барилга, хот байгуулалтын яам

БСШУЯ-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

СЗХ-Санхүүгийн зохицуулах хороо

МЭҮГ-Мал эмнэлэг, үржлийн газар

МУСҮТ-Малын удмын сангийн үндэсний төв

ОБЕГ-Онцгой байдлын Ерөнхий газар

ГЕГ-Гаалийн Ерөнхий газар

НДЕГ- Нийгмийн даатгалын Ерөнхий газар

МХЕГ-Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

ҮСГ-Үндэсний статистикийн газар

ОУБ-олон улсын байгууллага

ХААБ-Хөдөө аж ахуйн бирж

СХЗГ-Стандартчилал, хэмжил зүйн газар

ХХААГ-Хүнс, хөдөө аж ахуйн газар

ЭШХ-Эрдэм шинжилгээний хүрээлэн

УМЭАЦТЛ-Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори

МХС-Мал хамгаалах сан

МААЭШХ-Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн

**"МОНГОЛ МАЛ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2 ДАХЬ ҮЕ ШАТНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	2008 оны түвшин	2015 онд хүрэх түвшин	2010-2015 онд хүрсэн түвшин	Эх үе шатын Үнэлгээ	2021 онд хүрэх түвшин
<b>1. Нэгдүгээр тэргүүлэх чиглэл: Салбарын эрх зүй, эдийн засаг, бүтэц, зохион байгуулалтын нэн таатай орчныг бүрдүүлж, тогтвортой хөгжлийг хангах, мал аж ахуйн салбарт сайн засаглалыг хөгжүүлэх:</b>						
1.1. Мал аж ахуйн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох		Үйл ажиллагааны хэрэгжилтээр			<b>70</b>	
Төрийн үйлчилгээний алба	тоо	-	338	332	<b>70</b>	-
Хувийн хэвшлийн үйлчилгээний нэгж \шинээр\.	тоо	751	75	960	<b>70</b>	<b>135</b>
1.3. Мал аж ахуйн мэргэжилтэн, малчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх:						
Шинээр давтан сургасан мэргэжилтэн	тоо, өссөн дүнгээр	104	1,908	16,132	<b>90</b>	<b>2,120</b>
Малчны түр сургууль төгсөгчид	тоо, өссөн дүнгээр	25	10,200	8,375	<b>70</b>	<b>17,000</b>
<b>Дундаж үнэлгээ</b>					<b>74</b>	
<b>2. Хоёрдугаар тэргүүлэх чиглэл: Малын үржлийн ажил, үйлчилгээг боловсронгуй болгож, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулан, биологийн төгс чанартай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх:</b>						
2.1. Малын удмын санг хамгаалах ажлын хүрээнд:						
Малын удмын сангийн үндэсний цогцолбор	тоо	-	1	1	<b>80</b>	
Бүсүүдэд байгуулагдсан мал үржүүлэг, биотехнологийн салбар	тоо	-	2	1	<b>50</b>	
Зохиомлоор хээлтүүлэх мал	тоо, өссөн дүнгээр	3,200	24,000	97,207	<b>70</b>	<b>120,000</b>
2.2. Дотооддоо үйлдвэрлэх, импортоор авах үржүүлгийн бүтээгдэхүүн:						
Дотооддоо үйлдвэрлэсэн үр	тоо, өссөн дүнгээр	21,000	60,000	32,252	<b>54</b>	<b>195,000</b>
Импортлосон үр, хөврөл үр	тоо, өссөн дүнгээр	7,000	30,000	49,727	<b>70</b>	
2.3. Оны эхний малын тоо	мян.тол	43,288	35,299	55,958	<b>90</b>	<b>36,476</b>
үүнээс: төрөл тус бүрээр:						
тэмээ	хувь	0.6	0.8	0.7	<b>90</b>	<b>0.9</b>
адуу	хувь	5.1	6.8	5.9	<b>90</b>	<b>8.2</b>
үхэр	хувь	5.8	9.6	6.8	<b>90</b>	<b>13.8</b>
хонь	хувь	42.4	45.4	44.6	<b>90</b>	<b>45.1</b>
ямаа	хувь	46.1	37.4	42.1	<b>90</b>	<b>32.0</b>
2.4. Нэг малаас авах ашиг шим:						
Цэвэр, эрлийз үнээний сүү	305 хоног/ кг	1,769	2,673	2,025	<b>70</b>	<b>3,200</b>
Ноолуур	грамм	290	300	350	<b>100</b>	<b>310</b>
Нарийн, нарийвтар ноос	кг	4	4	3	<b>50</b>	<b>5</b>
Бүдүүн, бүдүүвтэр ноос	кг	1	1	1	<b>100</b>	<b>1</b>

2.5.Малын бүртгэл мэдээллийн сан, сүлжээг бий болгох:						
Сүлжээнд хамрагдсан нэгж	тоо	-	338	302	50	
Бүртгэлжүүлэх мал, өссөн дүнгээр	хувь	0	60	15	30	80
<b>Дундаж үнэлгээ</b>					<b>74.3</b>	
<b>3.Гуравдугаар тэргүүлэх чиглэл: Мал эмнэлгийн ажил үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, монгол малын эрүүл мэндийг баталгаажуулан нийгмийн эрүүл мэндийг хамгаалах:</b>						
3.1.Монгол Улс дараахь өвчнөөр тайван, өвчингүй статусыг ДМАЭМБ-аас авах:						
Үхрийн цээж		-	сертификат	-	50	
Үхрийн тархины эд сархиатах		-	-	-	50	
Шүлхий		-	-	-	50	
Хонь, ямааны цэцэг		-	-	-	50	
3.2. Малыг дараахь төрлийн өвчнөөс эрүүлжүүлэх:						
Үхэр, тэмээг бруцеллөз өвчнөөс	хувь	98	100		70	-
Адууг ям өвчнөөс	хувь	98	100		70	-
Халдварт цус багасах өвчнөөс	хувь	99	100		70	-
Сүүний үхрийг лейкоз өвчнөөс	хувь	75	100		70	-
Бог малыг бруцеллөз өвчнөөс	хувь	100	100		70	100
Бруцеллөзоос тайван бус нийт малчин өрх /одоо 3,5-11,7 хувь/	хувь	8	0		70	0
3.3. Малыг гоц халдварт өвчний дэгдэлт гараагүй байх:	Малын гоц халдварт шүлхий өвчин 2000, 2001, 2002, 2004, 2005, 2006, 2010, 2014, 2015 онуудад тус тус оношлогдож, тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.					
	Шүлхий өвчин 2015 онд Сүхбаатар, Баян-Өлгий, Ховд аймгийн нэр бүхий 5 суманд 9 удаагийн голомтоор гарч 1024 мал өвчилж, 90 толгой малыг устгасан.					
	Манай оронд хонь ямааны цэцэг өвчин 1967, 1977 онуудад бүртгэгдэж, түүнээс хойш тайван байж байгаад 2006 оны 11 сард Сүхбаатар аймгийн Асгат, Баруун урт сумдад анх оношлогдож 2006-2007 онд нийт 7 сумын 14 голомтонд 978 хонь өвчилсөн байна. Ямааны цэцэг өвчин 2008 онд Дорнод аймгийн Хэрлэн,Баянт үмэн сумдад оношлогдож, нийт 423 ямаа өвчилсөн бүртгэгдсэн. Хонины цэцэг өвчин 2013 оны 1 дүгээр сард Дорнод аймгийн Хатанбулаг суманд оношлогдож тэмцэх зааврын дагуу арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Хонины цэцэг өвчин 2015 онд Дорнод аймгийн Баянтүмэн суманд анх оношлогдож улмаар хил залгаа Сүхбаатар, Хэнтий, Дорноговь аймгийн 22 сумын нутаг дэвсгэрт халдварлаж нийтдээ 54 удаагийн голомтоор 1431 толгой мал, амьтан өвчилж 78 толгой малыг зааврын дагуу устгасан.					
3.4. Сум, дүүрэгт мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн магадлан шинжилгээ хийх чадавхитай болох:	лабораторийн тоо	120	106	55	30	-
3.5. Малыг өвчний оношлогооны явууллын үйлчилгээ бий болгох:	тоо	-	-	5	70	25
3.6. Малыг эм, биобэлдмэл /вакцин, оношлуур/-ийг дотооддоо үйлдвэрлэх:	хувь	70	85	90	90	100
<b>Дундаж үнэлгээ</b>					<b>57.8</b>	
<b>4. Дөрөвдүгээр тэргүүлэх чиглэл: Уур амьсгал, байгаль экологийн өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эрсдэл даах чадавхийг сайжруулах:</b>						
4.1. Улс, аймаг, сумын отрын бүс нутгийн түвшинд хамгаалалтад авах бэлчээрийн хэмжээ:	хувь	1	5	1	14	10
4.2. Малыг тоо, төрлийг бэлчээрийн даацтай уялдуулан малын тооны дээд хязгаарыг /квот /тогтоох:	Үйл ажиллагааны хэрэгжилтээр				0	

4.3. Аймаг, сум бүрт өвс, тэжээлийн нөөцийн сан, тэжээлийн цех бий болгох:	тоо	38	150	64	30	150
4.4. Бэлчээр сайжруулах арга хэмжээ:						
Шинээр гаргасан инженерийн хийцтэй худгийн тоо	тоо	1,314	3,600	6,045	100	3,600
Бэлчээрийн хортон, мэрэгч амьтантай тэмцсэн талбай	мян.га, өссөн дүнгээр	700	3,000	4,270	100	3,000
4.5. Малын даатгалын тогтолцоог боловсронгуй болгох:						
Малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо	хувь, өссөн	3	15	6,7*	50	20
4.6. Бэлтгэх тэжээлийн хэмжээ:						
Нийт үйлдвэрлэсэн тэжээл	тэж.нэгж, мян. тн, өссөн дүнгээр	561	700	614*	90	900
Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн тэжээл	хувь, өссөн	10	30	30	100	40
<b>Дундаж үнэлгээ</b>					<b>60.5</b>	
<b>5.Тавдугаар тэргүүлэх чиглэл: Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлж, бэлтгэл, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох, урамшуулал олгох замаар эдийн засгийн эргэлтийг хурдасгах:</b>						
5.1. Мал нядалгааны цех бий болгох	тоо, өссөн дүнгээр	25	-	36	70	-
5.2. Мах, нядалгааны жингээр нийт үйлдвэрлэсэн махны хэмжээ:	мян.тн	223	354	448	100	324
Үүнээс:						
үйлдвэрийн аргаар боловсруулсан	мян.тн	15	71	12	16	157
экспортод гаргасан	мян. тн	10	33	5	15	50
5.3. Нийт үйлдвэрлэсэн сүүний хэмжээ:	мян.тн	457	524	874	100	623
Үүнээс:						
Үйлдвэрийн аргаар боловсруулсан	мян.тн	17	52	70	100	125
5.4. Дотоодын үйлдвэрүүдэд нийлүүлсэн, гарал үүсэл нь тодорхой бүтээгдэхүүнд чанараас хамааран урамшуулал олголт	Хөтөлбөрийн эхний шат буюу 2011- 2014 онуудад үндэсний үйлдвэрт хонь, тэмээний ноосоо тушаасан 334.4 мянган /давхардсан тоогоор/ малчин, мал бүхий иргэдийн 54.5 тонн ноосонд нийт 94.1 тэрбум төгрөгийн урамшууллыг олгосон.				90	
	Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу ноосны урамшууллыг ноосны чанар, үүлдэрлэг байдлаас хамааран ялгавартайгаар олгодог болсон ба хонины нарийн, нарийвтар ноос болон тэмээний ноосонд 2000 төгрөгөөр бодож 7634 хоршооны гишүүн малчин, мал бүхий иргэний бэлтгэсэн 1.75 мянган тонн ноосны 1.7 тэрбум төгрөгийг Монголбанк дахь Мал хамгаалах сангийн “Малчин” дансанд байршуулж малчдын арилжааны банк дахь дансны мэдээллийг шалгаж, шилжүүлээд байна.					
	Улсын Их Хурлын 2013 оны 74 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 30 өдрийн 394 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох тухай журам”-ын хүрээнд 2013 оны сүүлийн хагас жил болон 2014 оны эхний хагас жилд үндэсний боловсруулах үйлдвэрт түүхий эд тушаасан малчин, мал бүхий этгээдэд дараах урамшууллыг олгоод байна.					
	Тайлант 2015 онд Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны А-110 дугаар тушаалаар 21 аймаг, нийслэлийн 54535 хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдийн үндэсний үйлдвэрт тушаасан 1854943 ширхэг бог, 159654 ширхэг бод, нийт 2014597 ширхэг арьс ширэнд 7959.6 сая төгрөгийн					

	урамшууллын санхүүжилтийг Монголбанкн дахь “Малчин” дансанд байршуулж малчдын арилжааны банкн дахь дансанд шилжүүлээд байна.		
5.5. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний биржийн сүлжээ бий болгох	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны 03 сарын 07-ны өдрийн А/35 тоот тушаалаар биржээр Хонины ноос, ноолуур арилжих тухай “Бараа, түүхий эдийн жагсаалт, ангилалын код”, “Бараа түүхий эдийг коджуулах журам”-ыг батлан, ҮХАА-н сайдын 2013 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/135 дугаар тушаалаар биржээр арилжих барааны жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, хүнсний буудай болон тосны ургамал /рапс/, малыг биржээр арилжих барааны жагсаалтанд оруулан батлуулж, Хүнсний буудай, амьд мал биржээр арилжиж байна.	90	
	<b>Дундаж үнэлгээ</b>	<b>72.6</b>	
	<b>Дундаж үнэлгээ</b>	<b>67.8</b>	